

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№21/540

ШУС, НУС

2020

ТӨРИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН ШИЛЭН ДАНСНЫ
ХӨТЛӨЛТӨД ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ
(Монголросцветмет ТӨҮГ-ын жишээн дээр)

Д.Идэржаргал*, Б.Түвшинтөр**

* МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (МА)

** ХУИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн багш, магистр (МА)

Түлхүүр үг: Мэдээллийн ил тод байдал, нээлттэй өгөгдөл, дата сэтгүүл зүй, өгөгдлийн сэтгүүл зүй, шилэн данс, төрийн өмчит уул уурхайн компани

Монгол Улсад мэдээлэл, өгөгдлийн ил тод байдлын эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар багагүй ахиц дэвшил гарч байна. Тодруулбал,

- ✓ Засгийн газрын 159 дүгээр тогтоол¹ (2017 он)
- ✓ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль² (2011 он)
- ✓ Шилэн дансны тухай хууль³ (2014 он)-ийг баталснаар хуульд заасан төрийн байгууллагууд мэдээллээ олон нийтэд ил тод тайлагнах эрх зүйн орчин бүрдээд удаж байна.

Мөн Засгийн газрын 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт мэдээллийн ил тод байдлыг эрчимтэй хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх талаар тусган ажилласныг энд онцлох хэрэгтэй. Үүний хүрээнд төрийн мэдээллийн нэгдсэн систем бий болгох, мэдээллийн менежментийг сайжруулах чиглэлээр хүчин чармайлт гаргаснаар Монгол Улс нээлттэй өгөгдлийн мэдээллийн сан хөгжүүлэх боломжтой болсныг “Ухаалаг

засаг” төслийн хүрээнд хийгдсэн “Монголын Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ” (Open data readiness assessment Mongolia) судалгааны тайланд⁴ дурджээ. Тодруулбал,

- ✓ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Нээлттэй өгөгдлийн бодлогын төсөл, Өгөгдөл хамгааллын хуулийн төсөл болон “e-Governance” үндэсний хөтөлбөр;
- ✓ Үндэсний дата төвийн (Төрийн мэдээлэл солилцооны дэд бүтцийг хөгжүүлэх) “Хур” болон “Хурд” систем;
- ✓ Үндэсний статистикийн хорооны www.1212.mn сайт (төрийн нээлттэй өгөгдлийг хуваалцаж буй шилдэг туршлага);
- ✓ Засгийн газар, Төрийн өмчийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын (Нээлттэй засгийн газрын түншлэл, Нээлттэй өгөгдлийн санаачилгын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн төрийн нээлттэй өгөгдлийг хуваалцаж буй шилдэг туршлага)
- ✓ www.opendata.tender.gov.mn сайт;
- ✓ Улсын бүртгэлийн ерөнхий газрын (Улсын бүртгэлийн багц хуулийн хүрээнд) хуулийн этгээдүүдийн бүртгэлийн мэдээллийг ил тод

болгосон

www.opendata.burtgel.gov.mn сайт;

- ✓ “Ухаалаг засаг” төслийн нээлттэй өгөгдлийн программуудыг санхүүжүүлж, технологийн тусламж, зөвлөгөө өгч буй ажлуудыг онцгойлон сайшааж дээрх төрийн байгууллагууд хууль ёсны шаардлагыг хангах үүднээс өгөгдлийг олон нийтэд нээлттэй, машинаар уншиж болохуйц стандарт хэлбэрээр нийтэлж хэвшсэнийг тэмдэглэжээ.

Мэдээллийн ил тод байдал, нээлттэй өгөгдлийн эрх зүйн орчин бүрэлдэж байгаа энэ нөхцөлд эхэнд дурдсан хуулиудын хэрэгжилт, түүний хүрээнд хийгдэж буй төслүүдийн үр дүнд хяналт тавих нь цаашид эрх зүйн орчныг чамбайруулахад нэн чухал үүрэгтэй. Тиймээс Монголын Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл (ТНЗ) нь Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн олон улсын байгууллагаас тэтгэлэг авч, “Төрийн өмчит уул уурхайн компаниудын шилэн дансанд мэдээллийн дүн шинжилгээ хийх” төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд сэтгүүлчид мэдээллийг олж авах, боловсруулах үр чадварт суралцангаа Шилэн дансны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, түүндээ үндэслэн сэтгүүл зүйн ажлаар асуудлыг олон нийтэд хүргэх, улмаар шилэн дансны тайлагналыг сайжруулах, илүү ахисан түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх талаар санал зөвлөмж гаргах ёстой.

Төсөлд оролцогчид төрийн өмчит уул уурхайн компаниудын шилэн дансны хөтлөлтөд мэдээллийн дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ шилэн дансны мэдээллийнх нь дүн шинжилгээнд үндэслэн сэтгүүл зүйн бүтээл гаргахаар ажиллаж буй төрийн өмчит уул уурхайн компани болох

“Монголросцветмет”-ийг жишээ болгон авав.

Мэдээллийн дүн шинжилгээний ач холбогдол: Төрийн өмчит уул уурхайн компаниудын шилэн дансны хөтлөлтөд мэдээллийн дүн шинжилгээ хийснээр

1. Төрийн өмчит уул уурхайн компаниуд шилэн дансаа хөтөлж байгаа эсэхийг тодорхойлох
2. Хэрвээ шилэн дансаа хөтөлж байгаа бол хуульд заасны дагуу бүрэн дүүрэн, ил тод, шуурхай хөтөлж буй эсэхийг нягтлах, ингэснээр шилэн дансны хөтлөлт дэх зөрчлийг олж илрүүлэх
3. Цаашид шилэн дансны хөтлөлтийг сайжруулахад тус болох менежментийн, хариуцлагын тогтолцооны талаар санал зөвлөмж гаргах
4. Олон нийтэд мэдээллийн ил тод байдлын хуулиуд хийгээд түүний хэрэгжилтийн ач холбогдлын бодит жишээн дээр тулгуурлан ойлгуулах зэрэг ач холбогдолтой.

М эдээллийн дүн шинжилгээ хийсэн арга зүй: Төрийн өмчит уул уурхайн компаниудын шилэн дансны хөтлөлтөд мэдээллийн дүн шинжилгээ хийхдээ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг гол үндэслэл болгов. Мөн Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг үндэс болгон ажиллав. Ингэхдээ:

1. Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 4-р зүйл болох “Төрийн байгууллага, албан газрын тавих мэдээллийн агуулга, хэлбэр”-ийг хангаж буй эсэхийг,
2. Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйл болох “Шилэн дансны мэдээлэл”-ийн тодорхой заалтуудыг

хэрэгжүүлж буй эсэхийг, хэрэгжүүлж байгаа тохиолдолд ямар түвшинд байгааг,

3. Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйл болох “Шилэн дансны зарчим” хангагдаж буй эсэхийг нягтлан шалгав.

2020 оныг дуустал компаниуд шилэн дансаа хэрхэн хөтөлснийг шинжлэхдээ дараах алхмуудаар ажиллав.

1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын жагсаалтыг гаргах
2. Жагсаалтад орсон компани тус бүр шилэн дансаа хөтөлж буй эсэхийг шалгах
3. Шилэн дансаа хөтөлж буй компаниуд ямар түвшинд хөтөлж буйг

шинжлэхдээ жишиг болгон нэг компани сонгон авах

4. Сонгосон компанийн шилэн дансны хөтлөлтөд сонгон авсан хууль, журмуудын тодорхой зүйл заалтын дагуу дүн шинжилгээ хийх

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын бүрэн жагсаалтыг эхлээд гаргав. Энэхүү мэдээллийг олохоор Ашигт малтмал, газрын тосны газар⁵, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам⁶, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын⁷ сайтуудаас хайж үзсэн ч олдсонгүй. Тиймээс www.shilendans.gov.mn сайтын “Төрийн өмчит аж ахуйн нэгж” булангаас⁸ шүүж төрийн өмчит уул уурхайн компаниудын жагсаалтыг дараах байдлаар гаргав.

№	Төрийн өмчит уул уурхайн компанийн нэр	Төрийн өмчлөлийн хувь	Төрийн өмчлөлийн хэлбэр
1.	Эрдэнэс Тавантолгой	85%	Шууд төрийн өмчит компани
2.	Эрдэнэс Монгол ХХК	100%	Шууд төрийн өмчит компани
3.	Эрдэнэс Алт Ресурс	100%	Шууд төрийн өмчит компани
4.	Эрдэнэс Силвер Ресурс ХХК	100%	Шууд төрийн өмчит компани
5.	Шивээ Овоо ХК	90%	Олон нийтэд нээлттэй Төрийн өмчит компани
6.	Багануур ХК	75%	Олон нийтэд нээлттэй Төрийн өмчит компани
7.	Эрдэнэт Үйлдвэр	51% +49%	Онцгой дэглэм тогтоосон УУГ
8.	Монголросцветмет	51%+49%	Онцгой дэглэм тогтоосон УУГ
9.	Тавантолгой ХК	51%	Орон нутгийн өмчит ХК
10.	Могойн гол ХК		Орон нутгийн өмчит ХК
11.	Баянтээг ХК	70%	Орон нутгийн өмчит ХК

Хүснэгт 1. Төрийн өмчит уул уурхайн компаниудын жагсаалт.

А. Төрийн өмчит уул уурхайн компаниуд шилэн дансаа хөтлөхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төрийн өмчит уул уурхайн компаниуд нь 2015 оноос эхлэн шилэн дансандаа дараах есөн төрлийн мэдээллийг

заасан хугацаанд байршуулсан байх ёстой.

1. Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн

- жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
2. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр).

Төрийн өмчит уул уурхайн компаниуд шилэн дансаа хөтөлж буй эсэхийг нягтлахдаа шаардлагатай мэдээллийг оруулсан эсэхийг л авч үзсэнээс оруулсан мэдээлэл нь стандарт шаардлага хангасан эсэхийг авч үзээгүйг анхаарна уу. Ингэхдээ:

- ✚ Холбогдох мэдээллийг тухайн жилд огт хөтлөөгүйг улаан өнгөөр,
- ✚ Холбогдох мэдээллийг тухайн жилийн шаардлагатай саруудын тал хүрэхгүй хугацаанд хөтөлсөн бол шар өнгөөр,
- ✚ Холбогдох мэдээллийг тухайн жилийн шаардлагатай саруудын тал болон талаас дээш хугацаанд хөтөлсөн бол улбар шар өнгөөр
- ✚ Холбогдох мэдээллийг тухайн жилийн шаардлагатай бүх бүх сард хөтөлсөн бол ногоон өнгөөр дүүргэн тэмдэглэв.
- ✚ Компани тухайн жилд байгуулагдаагүй байсан бол саарал өнгөөр тэмдэглэв.

Төрийн өмчит уул уурхайн компани	Шилэн дансанд байршуулах ёстой мэдээлэл	Шилэн дансаа хөтөлсөн байдал (харгалзах оноор)					
		2015	2016	2017	2018	2019	2020
1. Эрдэнэс Тавантолгой	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	✚	✚	✚	✚	✚	✚
	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	✚	✚	✚	✚	✚	✚
	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	✚	✚	✚	✚	✚	✚
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	✚	✚	✚	✚	✚	✚
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	✚	✚	✚	✚	✚	✚
	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	✚	✚	✚	✚	✚	✚
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	✚	✚	✚	✚	✚	✚

	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Red	Red	Green
2. Эрдэнэс Монгол ХХК	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Red	Red	Red	Red	Red	Yellow
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	Red	Red	Red	Red	Green	Green
	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Red	Red	Green
	3. Эрдэнэс алт ресурс	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Grey	Grey	Grey	Grey	Red
Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)		Grey	Grey	Grey	Grey	Green	Green
Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)		Grey	Grey	Grey	Grey	Yellow	Green
Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)		Grey	Grey	Grey	Grey	Green	Yellow
Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)		Grey	Grey	Grey	Grey	Green	Yellow
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)		Grey	Grey	Grey	Grey	Yellow	Yellow
Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)		Grey	Grey	Grey	Grey	Green	Yellow
Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)		Grey	Grey	Grey	Grey	Green	Red
Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)		Grey	Grey	Grey	Grey	Green	Green
4. Эрдэнэс Силвер Ресурс ХХК	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Grey	Grey	Grey	Grey	Red	Yellow
	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	Grey	Grey	Grey	Grey	Red	Red
	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	Grey	Grey	Grey	Grey	Red	Green

	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)							Red	Yellow	
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)							Red	Yellow	
	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)							Red	Yellow	
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)							Red	Red	
	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)							Red	Green	
5. Шивээ Овоо ТӨОХК	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)							Red	Red	
	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)							Red	Red	
	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)							Red	Yellow	
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)							Green	Green	
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)							Red	Red	
	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)							Red	Red	
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)							Red	Red	
	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)							Red	Red	
	6. Багануур ХК	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Red	Red	Red	Red	Red	Red	Red	Yellow
		Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Red	Red	Red	Red	Red
Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)		Red	Red	Red	Red	Red	Red	Red	Yellow	
Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)		Red	Red	Red	Red	Red	Red	Red	Red	
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)		Red	Red	Red	Green	Green	Red	Red	Yellow	
Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)		Red	Red	Red	Red	Red	Red	Red	Red	
Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)		Red	Red	Red	Red	Red	Red	Red	Red	
Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)		Red	Red	Red	Red	Red	Red	Red	Red	

7. Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Red	Red	Red	Red	Yellow	Green
	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Green	Green	Green
	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	Red	Red	Red	Red	Green	Green
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Red	Red	Red	Green	Green	Yellow
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	Red	Red	Red	Red	Green	Yellow
	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Red	Red	Red	Green	Yellow	Yellow
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Green	Green	Red
8. Монголросцветмет	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Red	Red	Red	Red	Yellow	Green
	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Red	Green	Green
	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	Red	Red	Red	Red	Yellow	Green
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Red	Red	Red	Red	Green	Yellow
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	Red	Red	Red	Red	Yellow	Green
	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Red	Red	Red	Red	Green	Yellow
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Red	Green	Red
9. Тавантолгой ХК	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Red	Red	Red	Red	Red	Red
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	Red	Red	Red	Red	Red	Red

	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)								
10. Могойн гол ХК	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)								
	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)								
	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)								
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)								
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)								
	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)								
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)								
	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)								
11. Баянтээг ХК	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)								
	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)								
	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)								
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)								
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)								
	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)								
	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)								
	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)								

Хүснэгт 2. Төрийн өмчит уул уурхайн компаниуд шилэн дансанд оруулах ёстой мэдээллүүдээ байршуулсан үзүүлэлт.

Дээрх хүснэгтээс дараах дүгнэлтийг хийв.

1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниуд 2015 оноос хэрэгжиж эхэлсэн Шилэн дансны хуулийг 2018 оныг дуустал огт хэрэгжүүлсэнгүй. 2018 онд хоёрхон компани шилэн дансаа

хөтөлж эхэлсэн ч тун хангалтгүй. Багануур ХК нийт оруулах ёстой мэдээллийн 11%, Эрдэнэт үйлдвэр 57%-ийг л шилэн дансны мэдээлэлдээ оруулжээ.

2. Орон нутгийн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниуд шилэн дансаа

огт хөтөлдөггүй, өнөөдрийг хүртэл нэг ч мэдээлэл оруулаагүй байна.

3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн дийлэнх компани шилэн дансаа 2019, 2020 онд л хөтөлжээ.
4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудаас шилэн дансаа зохих ёсоор, бүрэн дүүрэн хөтөлсөн нэг ч компани (бүгд ногоон өнгөтэй) байхгүй байна.
5. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудаас шилэн дансаа зохих онд нь хөтөлсөн 3 компани л байна. Эдгээр нь Эрдэнэт алт ресурс, Эрдэнэт силвер ресурс, Шивээ овоо компаниуд юм.
6. Шилэн дансаа хөтөлсөн компаниудыг шаардлагатай мэдээллүүдийг (тухайн мэдээллийн шаардлага хангаж байгаа эсэх тухай асуудал үүнд хамаараагүй болно) ямар хувьтай нийтэлснээр нь жагсаавал (Оруулах ёстой нийт мэдээллийг 100% гэж үзээд тухайн хөтөлсөн онд хэдэн хувийг оруулсныг гарган, хөтөлсөн онуудын дунджаар компани тус бүрийн хөтлөлтийн нийт хувийг гаргав):
 1. Монголросцветмет- 93% (2019, 2020 онд хөтөлсөн)
 2. Эрдэнэт үйлдвэр – 81% (2018, 2019, 2020 онд хөтөлсөн)
 3. Эрдэнэс алт ресурс- 89% (2019, 2020 онд хөтөлсөн)
 4. Шивээ Овоо- 75% (2019, 2020 онд хөтөлсөн)
 5. Эрдэнэс Тавантолгой – 75% (2020 онд хөтөлсөн)
 6. Эрдэнэс силвер ресурс- 75% (2020 онд хөтөлсөн)
 7. Эрдэнэс Монгол- 25% (2019, 2020 онд хөтөлсөн)

8. Багануур ХК- 21% (2018, 2019, 2020 онд хөтөлсөн)

Б. Монголросцветмет ТӨҮГ шилэн дансаа агуулга, стандартад нийцүүлэн хөтөлж байгаа ч алдаа дутагдал олон байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудаас Монголросцветмет компанийг сонгон авч бол шилэн дансаа хуульд заасны дагуу бүрэн дүүрэн, ил тод, шуурхай хөтөлж буй эсэхийг нягталлаа.

Монголросцветмет компанийн шилэн дансны мэдээлэлд дүн шинжилгээ хийхээр сонгосон нь дараах шалтгаантай:

1. Нэн тэргүүний үндэслэл нь Монголросцветмет нь шилэн дансаа хамгийн бүрэн дүүрэн хөтөлсөн компани юм. (Энд шаардлагатай мэдээллийг оруулсан эсэхийг л авч үзсэнээс оруулсан мэдээлэл нь стандарт шаардлага хангасан эсэхийг авч үзээгүйг анхаарна уу). Тиймээс дүн шинжилгээ хийх мэдээллийн олдоц болон иж бүрэн байдлын хувьд давуу талтай гэж үзэв.
2. Монголросцветмет нь хайлуур жоншны хүдэр олборлолт, баяжуулалт; төмрийн хүдэр олборлолт, баяжуулалт; алт олборлолт, баяжуулалт; хайрга, дайрга, элс үйлдвэрлэл, геологи хайгуулын ажлын чиглэлээр тус тус үйл ажиллагаагаа явуулан, жилд 550-600 мянган тонн хайлуур жоншны хүдэр, 2.4 сая тонн төмрийн хүдэр олборлон, 320-400 мянган тонн төмрийн баяжмалыг боловсруулж, 110-120 мянган тонн жоншны баяжмал үйлдвэрлэн, 2.0 сая тонн алт агуулсан элс угааж нийт 1300 гаруй хүнийг ажлын байраар тогтмол ханган ажилладаг⁹ Монголын томоохон ТӨҮГ-ын хувьд

сонирхол татсан. Тус компани 2019 онд улсад 13 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна.

45 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа Монголросцветмет компани 2015 оноос хэрэгжиж эхэлсэн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхгүй явсаар 2019 онд Төрийн Өмчийн Үйлдвэрийн газар болсноосоо хойш Шилэн дансаа тогтмол хөтөлдөг болсныг shilendans.gov.mn-ээс харж болно. Тодруулбал, Засгийн газрын 2019 оны гуравдугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар тус компанийг ТӨҮГ болгох шийдвэр гарсан цагаас эхлэн буюу 2019 оны дөрөвдүгээр сараас хойших шилэн дансны мэдээлэл оржээ. Гэтэл Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т зааснаар хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 2015 оноос эхлэн шилэн дансыг хөтлөх ёстой байсан ч дөрвөн жил хууль хэрэгжүүлэлгүй явж иржээ.

Монголросцветмет компани төрийн өмчит уул уурхайн бусад компаниудтай харьцуулахад шилэн дансыг харьцангуй сайн хөтөлж байгааг дурдах нь зүйтэй. Гэвч хууль, журамд заасан цөөн мэдээллийг оруулахгүй байсаар байгаа бөгөөд Шилэн дансны тухай хуулийн дөрөвдүгээр зүйлд заасанчлан мэдээллийн иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтмол, шуурхай байх зарчмууд биелэхгүй байх дутагдал мэдээлэлд дүн шинжилгээ үе шатанд маш их гарч байна. Шилэн дансыг хөтлөх зарчмыг ингэж баталжээ¹⁰.

4.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;

4.1.2.мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;

4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;

4.1.4.хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх.

Тухайлбал, Төрийн өмчийн ААН, байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбар гэсэн хэсэгт 2019 оны тухайд бүх мэдээллийг оруулсан байна. Гэвч тухайн мэдээллүүдийг ороод үзэхээр нэгдүгээр сарыг эс тооцвол бусад сарын хэмнэлт, хэтрэлт дээр шалтгааныг нь тодорхой бичээгүй байгаа тул хэмнэгдсэн зардлыг юунд зарцуулж, ямар үр ашиг гаргаж байгаа нь тодорхойгүй болж байна. 2020 оны тухайд уг цэс рүү ороход мэдээлэл оруулсан мэт чеклэсэн байгаа ч ороод харахаар “нэмэлт өөрчлөлт ороогүй” гэсэн тайлбар бичсэн нь энгийн иргэдийг төөрөгдүүлэхээр байв. Гэвч эдгээр мэдээллийг оруулах хуулийн заалттай байна. Тодруулбал, “6.1.6. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам-ын “4.1.2. төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшнийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 17 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;” гэсэн заалт биелэхгүй байна.

2020 онд 2021 оны төсвийн төслөө бүтнээр нь байршуулах ёстой ч уг мэдээллээ өнөөдрийг хүртэл тавиа-

гүй байгаа юм. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн “6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэснийг зөрчиж байна.

Монголросцветмет компанийн шилэн дансанд оруулж буй баримтууд хэлбэрийн хувьд нээлттэй өгөгдлийн шаардлагыг хангасангүй. Нээлттэй өгөгдөлд тавигддаг хоёр чухал шаардлага бий¹¹. Эхнийх нь хууль эрх зүйн, хоёр дахь нь техникийн шаардлага юм.

- ✓ Хууль эрх зүйн шаардлагыг хангахын тулд тухайн өгөгдлийг ашиглах, борлуулах, татаж авах зэргийг зөвшөөрсөн, нээлттэй өгөгдөл гэдгийг батлах лиценз буюу CC (Creative Commons) лиценз тавьсан байх шаардлагатай. Монгол Улсад нээлттэй өгөгдлийн тухай хууль байхгүйгээс төрийн байгууллагууд өгөгдлийг хуваалцахдаа ийм лиценз тавьдаггүй нь цаашид эрх зүйн маргаан үүсгэх сул тал болоод байна. Монголросцветмет компанийн хувьд ч бусад төрийн өмчит компаниудын адил шилэн дансанд байршуулсан мэдээллүүддээ нээлттэй өгөгдлийн ийм лиценз тавиагүй.
- ✓ Техникийн шаардлагын хувьд машин унших форматтай байх ёстой. Өгөгдөл нь техникийн хувьд нээлттэй байна гэдэг нь тэдгээрийг машинаар унших боломжтой буюу электрон хэлбэрээр нийтлэх ёстой бөгөөд ингэснээр хэн ч нийтлэг, чөлөөтэй ашиглах боломжтой программ хангамжийн хэрэгслээр өгөгдөлд нэвтрэх, ашиглах боломжтой болно. Өгөгдөл нь олон нийтийн сервер дээр нууц үг, галт ханын хязгаарлалтгүйгээр олон нийтэд ил тод, нээлттэй байх ёстой. Монголросцветмет компани шилэн дансан-

даа санхүүгийн тайлан мэдээллээ хавсаргаж оруулсан байгаа ч уг файлыг зургаар сканердсан болон PDF хувилбараар оруулсан байгаа тул шууд ашиглах боломжийг хязгаарлаж байна. Энэ нь вэбийг зохион бүтээгч Тим Бернерс Ли-гийн нээлттэй өгөгдлийг үнэлэх 5 одын схемийн¹² хувьд нээлттэй өгөгдөлд тавих шаардлагыг хамгийн бага түвшинд хангаж байгаа хэлбэр юм.

Нээлттэй өгөгдлийг үнэлэх 5 одын схемийг Дэлхийн банк нээлттэй өгөгдлийг үнэлэх арга зүйдээ оруулдгийг энд дурдах хэрэгтэй¹³. Тус схемийг дор тайлбарлая.

★Нээлттэй лицензийн дагуу вэбсайтаас (ямар ч хэлбэрээр) ашиглах боломжтой мэдээлэл. Pdf форматын мэдээлэл үүнд хамаарна.

★★Бүтэцлэгдсэн өгөгдөл хэлбэрээр ашиглах боломжтой мэдээлэл. Хүснэгтийн зургийг скан хийхийн оронд Excel хувилбараар оруулсан бол үүнд хамаарна.

★★★ Өмчийн бус нээлттэй хэлбэрээр оруулсан мэдээлэл. Excel-ийн оронд CSV ашиглах боломжтой бол үүнд хамаарна.

★★★★Юмсыг тэмдэглэхдээ URI-г ашигласан, ингэснээр хүмүүс вэб дээрх тухайн мэдээлэл рүү зааж өгөх боломжтой.

★★★★★ Хам сэдвийг хангахын тулд өгөгдлийг бусад өгөгдөлтэй холбох боломжтой.

Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл хэсгийг мөн л бүрэн хөтөлжээ. Харамсалтай нь, Шилэн дансны тухай хуулийн 6.3.7 “хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр” гэсэн

заалтыг зөрчсөн зөрчсөн байна. Тиймээс тус компанийн хаана, ямар зорилгоор хэрэгжүүлэх ямар төсөлд хэдэн төгрөг зарцуулж байгааг харах боломжгүй байна.

Шилэн дансны маягтыг бөглөхдөө бичиг хэрэг хөтлөлтийн стандарт, соёлыг баримтлаагүй, тухайлбал, харилцсан аж ахуйн нэгжийн нэрийг олон янзаар бичсэн, дутуу бичсэн зэрэг нь нэг байгууллагыг олон өөр байгууллага мэтээр харагдуулж байв. Мөн гүйлгээний утгыг оруулахдаа адил алдаа түгээмэл гаргажээ. Тухайлбал, 2019 оны 10 сарын 14-нд Бугант нандин ХХК- руу хийсэн 7 сая 560 мянган төгрөгийн гүйлгээний утгыг “10/70 шүд” гэж оруулсан байгаа нь шилэн дансны хэрэглэгчдэд тодорхой бүрэн мэдээлэл олгохгүй байна.

Монголросцветмет компанийн өөрийн цахим хуудаст¹⁴ ороод үзэхээр мэдээлэл нь мөн дутуу, зөрүүтэй зэрэг дутагдлууд байна. Тухайлбал, тус компанийн сайтад ажилчдын тоог 1205 гэсэн байгаа бол

шилэн дансан дахь 2020 оны төлөвлөгөөнөөс харахад 2019 онд 1,435, 2020 онд 1,480 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулахаар төлөвлөжээ. Мөн Охин компаниудын бие даасан шилэн данс байхгүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн стандартад заасан 5.1.1.шилэн дансны бие даасан цэстэй байх; гэсэн заалт зөрчигдөж байна.

Энэ мэт хуулийн хэрэгжилт дутуу дулимаг байхад хавсаргасан Аудитын тайланг нь нээж үзвэл “Зөрчилгүй” гэж дүгнэжээ.

Монголросцветмет компани “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын¹⁵ хэрэгжилтийг хэрхэн хангаж буйтай танилцана уу.

Тус журмын 4-р зүйлийн 4.1 заалтад “Хуулийн 3.1.1-д заасан төрийн байгууллага, албан газар дараах агуулга бүхий мэдээллийг дор дурдсан хэлбэрээр тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ” гэж заасныг дор задалж авч үзэв.

Д/д	Заалт	Бие-лэлт	Хугацааны хоцрогдол	Стандарт нийцэл
4.1.1.	худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, ...	тийм	Хоцрогдолтой /10 сар/	нийцтэй
4.1.1	...жилийн тайланг энэ журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тус тус цахимаар;	тийм	хоцрогдолгүй	нийцтэй
4.1.2.	төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшинг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, ...	үгүй	үнэлэх боломжгүй*	үнэлэх боломжгүй
4.1.2.	... гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар, улирал, хагас болон бүтэн жил ийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 17 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;	тийм	хоцрогдолгүй	нийцгүй
4.1.3.	дараа жилийн зорилтот түвшинг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар;	тийм	2021 оных хоцрогдолтой	нийцгүй
4.1.4.	тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар;	тийм	үнэлэх боломжгүй*	үнэлэх боломжгүй

4.1.5	хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, ...	тийм	хоцрогдолгүй	нийцгүй
4.1.5	... гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;	тийм	хоцрогдолгүй	нийцгүй
4.1.6	хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор, ...	тийм	үнэлэх боломжгүй*	үнэлэх боломжгүй
4.1.6	... жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;	тийм	хоцрогдолгүй	Нийцтэй
4.1.7	хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;	тийм	үнэлэх боломжгүй*	Нийцтэй
4.1.8	таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;	тийм	үнэлэх боломжгүй*	нийцтэй
4.1.9	цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хийгдсэнээс хойш зарлагын гүйлгээ бүрт түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт 7 хоногийн дотор энэхүү журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;	тийм	үнэлэх боломжгүй*	нийцтэй
4.1.10	зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар;	тийм	үнэлэх боломжгүй*	нийцтэй
4.1.11	хагас жилийн санхүүгийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	тийм	хоцрогдолгүй	нийцтэй
4.1.11	жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор цахимаар;	тийм	хоцрогдолгүй	нийцтэй
4.1.12	санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор PDF форматаар;	тийм	хоцрогдолгүй	нийцтэй
4.1.13	аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар;	тийм	хоцрогдолгүй	нийцтэй
4.1.14	тухайн байгууллага хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар;	үгүй	үнэлэх боломжгүй*	үнэлэх боломжгүй

4.1.15	худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар;	тийм	үнэлэх боломжгүй*	нийцтэй
4.1.16	байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн сарын тайланг энэ журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа сарын 8-ны дотор цахимаар;	тийм	хоцрогдолгүй	нийцтэй
4.1.17	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тухай бүр PDF форматаар.	тийм	үнэлэх боломжгүй*	нийцтэй

*Хүснэгт 3. Монголросцветмет компани “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангаж буй байдал. *Шилэн дансны сайтаас сар сараар харах боломжтой байгаа тул хуулийн хугацааг мөрдөж байгаа эсэхийг нягтлах боломжгүй.*

Монголросцветмет компанийн шилэн дансандаа оруулж буй мэдээлэл нь хэлбэр, хугацааны хувьд 63% нь журмын дагуу нийцтэй, 18% үнэлэх боломжгүй, 18% нь нийцгүй байна.

Тус компани Шилэн дансны тухай хуулийн¹⁶ холбогдох заалтын

хэрэгжилтийг хэрхэн хангаж буйтай танилцана уу.

Тус хуулийн 6-р зүйлд Шилэн дансанд оруулах мэдээллийн шаардлагыг дэд заалт тус бүрээр дор задалж авч үзэв.

Д/д	Заалт	хэрэгжилт
6.1.	Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:	хангалтгүй
6.1.1.	тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;	хангалттай
6.1.2.	хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;	хангалтгүй
6.1.3.	дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;	хангалтгүй
6.1.4.	жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;	хангалттай
6.1.5.	төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;	хангалттай
6.1.6.	төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.	хангалтгүй
6.2.	Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:	хангалттай
6.2.1.	эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт;	хангалттай
6.2.2.	орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/	хангалттай

6.2.3.	урсгал зардал /цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, хөрөнгийн зардал, татаас шилжүүлэг/	хангалттай
6.2.4.	хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт;	хангалттай
6.2.5.	улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа;	хангалттай
6.2.6.	зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/	хангалттай
6.3.	Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:	хангалтгүй
6.3.1.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт;	хангалттай
6.3.2.	төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт;	хангалттай
6.3.3.	төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар;	хангалтгүй
6.3.4.	өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх;	хангалтгүй
6.3.5.	хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт;	хангалттай
6.3.6.	хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл;	хангалттай
6.3.7.	хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр;	хангалтгүй
6.3.8.	тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт;	Үнэлэх боломжгүй
6.3.9.	орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.	Үнэлэх боломжгүй
6.4.	Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:	Хангалтгүй
6.4.1.	тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;	Үнэлэх боломжгүй
6.4.2.	тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;	хангалтгүй
6.4.3.	тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	хангалттай
6.4.4.	таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Хангалттай
6.4.5.	цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;	Хангалттай
6.4.6.	худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;	хангалттай
6.4.7.	байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;	хангалттай

6.4.8.	бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	хангалттай
6.4.9.	хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.	үнэлээгүй

Хүснэгт 4. Монголросцветмет компани Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж буй байдал.

Хэдийгээр Шилэн дансны тухай хууль 2015 оноос хэрэгжиж эхэлсэн нь төрийн өмчийг хэрэгжүүлдэг олон компанийн санхүүгийн мэдээллийг нээлттэй болгох боломж бүрдсэн ч бүрэн хэрэгжихгүй, нэгдсэн стандартгүй, мэдээллүүдээ дутуу оруулж байгаа тул хяналтыг илүү сайжруулах шаардлагатай нь ил тод харагдаж байна. Иймд дараах зөвлөмжийг санал болгож байна.

1. Компаниуд шилэн дансаа хөтлөхгүй байна. Шилэн дансны тухайн хуулийн 10 дугаар зүйлд заасан Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага заалт хэрэгжихгүй байгааг шилэн дансаа хөтлөөгүй компаниудад хариуцлага тооцохгүй байгаагаас харж болно. Тиймээс хуулийг биелүүлээгүй тохиолдолд хариуцлагын стандартыг чангатгах хэрэгтэй.
2. Компаниуд шилэн дансыг хөтлөхдөө мэдээллүүдээ бүрэн гүйцэт, ойлгомжтой, тодорхой мэдээлэх.
3. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг аж ахуйн нэгжүүд шилэн дансны мэдээллийг оруулахдаа мөрдөх, үүнийг хуульд тодорхой зааж өгөх шаардлагатай байна. Харилцсан компанийн албан ёсны нэрийг бичилгүй, өөр өөрөөр бичсэнээс болж харилцагч компани олон болж харагдах асуудал ажиглагдсан. Хувь хүний нэрийг овогтой, овоггүй бичих гэх мэт бүрэн гүйцэт бус мэдээлэл оруулж байгааг нэг стандартад оруулах.
4. Компани Шилэн дансны тухай хуулийн 5.1.2 дахь заалт “мэдээлэл

татаж авах, хэвлэх боломжтой байх” гэсэн нь сайтар хангагдаагүй. Нээлттэй өгөгдөлд тавигддаг техникийн шаардлагыг өнөө байгаа нөхцөлөөс илүү түвшинд хангуулах. Ингэснээр сэтгүүлчид, олон нийт нээлттэй өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд илүү хялбар, дөхөмтэй болох юм.

5. Нээлттэй өгөгдлийн лицензтэй болох. Энэ асуудлыг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай.
6. Хэрэв нэмэлт өөрчлөлт ороогүй, шинэ мэдээлэл нэмэгдээгүй бол иргэн шилэн дансны цахим хуудаст нэвтрээд харахад мэдээлэл оруулсан мэт зөвлөж харагдаж байгааг болиулах. Энэ нь шилэн дансны сайтын системийн үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай гэсэн үг юм.
7. Шилэн дансны сайтын загвар дизайныг сайжруулах. Тухайлбал, мэдээлэл оруулсныг батлах зөвлөмж тэмдэг дээр курсор очиход “энд дарж мэдээллийг үзнэ үү” гэсэн бичиг гардаг болгох. Наад захын энэ мэт загвар дизайны ээлгүй байдлаас болоод энгийн иргэд шилэн дансны мэдээллийг ухаж олж үзэхэд хүндрэлтэй байна.
8. Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын мэдээллүүдийг ойлгомжтой болгож, хуулийн дагуу төсөл, объектын нэр бүрээр тодорхой мэдээлэх, тайлбарыг бүрэн оруулж байх. Үүний тулд маягтын загварыг илүү ойлгомжтой болгож шинэчлэх.

9. Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын мэдээллүүдийг www.opendata.tender.gov.mn дээрх мэдээлэлтэй тус бүрчлэн холбож өгдөг болгох. Энэ нь мэдээллийн уялдаа холбоо, ил тод байдал, төрийн байгууллагын нээлттэй өгөгдлийн менежментийг улам бүр сайжруулна.

10. Шилэн дансан дахь мэдээллийг өөрчлөхдөө ямар шалтгаанаар ямар албан тушаалтан өөрчилсөн тухай мэдээлэл болон тэмдэглэгээ хийдэг байх. Юуны учраас өөрчлөлт орох болсон талаар тайлбар оруулдаг болгох.

11. Шилэн данс хөтлөх явцад мэдээллүүд ийнхүү дутуу дулимаг, бүрхэг байгаа нь хяналт сул байгаатай холбоотой хэмээн үзэж байгаа тул хариуцлагыг сайжруулж, буух эзэнтэй болгох.

Эшлэл

¹ <https://www.legalinfo.mn/annex/details/7897?lawid=12739>

² <https://www.legalinfo.mn/law/details/374>

³ <https://www.legalinfo.mn/law/details/10497>

⁴ https://www.smart.gov.mn/wp-content/uploads/2019/02/ODRA_report_en_g.pdf

⁵ <https://mrpam.gov.mn/>

⁶ <https://www.mmhi.gov.mn/>

⁷ <https://www.pcsp.gov.mn/>

⁸ <https://shilendans.gov.mn/orglist/4>

⁹ <http://www.mongolros.mn/p/1>

¹⁰ <https://www.legalinfo.mn/law/details/10497>

¹¹ <http://opendatatoolkit.worldbank.org/en/essentials.html>

¹² <https://5stardata.info/en/>

¹³ <http://opendatatoolkit.worldbank.org/en/odra.html>

¹⁴ <http://www.mongolros.mn/>

¹⁵ <https://www.legalinfo.mn/annex/details/6605?lawid=10807>

¹⁶ <https://www.legalinfo.mn/law/details/10497>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль
2. Шилэн дансны тухай хууль
3. <https://www.legalinfo.mn>
4. www.shilendans.gov.mn
5. https://www.smart.gov.mn/wp-content/uploads/2019/02/ODRA_report_en_g.pdf
6. <https://mrpam.gov.mn/>
7. <https://www.mmhi.gov.mn/>
8. <https://www.pcsp.gov.mn/>
9. <http://www.mongolros.mn>
10. <http://opendatatoolkit.worldbank.org>
11. <https://5stardata.info/en/>
12. <http://www.mongolros.mn/>

Summary

In this analysis, the author discusses the importance of information transparency and open data. In doing so, it examined the compliance of state-owned mining companies with the Glass Account Law, which was enacted to improve information transparency. It reviewed whether the information deposited in the glass accounts of state-owned mining companies met open data standards and requirements, and suggested ways to further improve it.